



23

ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 1193

Шивээговь сум

Газар эзэмших хугацааг сунгах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Илчлэг-Шивээ Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын эзэмшиж буй 4202000077, 4202000078 нэгж талбарын дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа нь дуусч байгаатай холбогдуулан газар эзэмших эрхийг хавсралтаар 40 жилээр сунгаж эзэмшүүлсүгэй.

2. Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг Илчлэг Шивээ Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захирал (Ш.Чинболд)-д үүрэг болгосугай.

3. Илчлэг-Шивээ Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ш.Чинболдтой газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Э.Баярмагнай)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2003 оны 35 дугаар захирамжийн Илчлэг-Шивээ Орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА


П.ГАНЧИМЭГ



421220033

Сумын Засаг дарын 2022 оны 1 дүгээр сарын
24-ний өдрийн А/13 дугаар захирамжийн хавсралт

Илчлэг-Шивээ ОНӨҮГ-ийн газар эзэмших нэгж талбарын жагсаалт



д/ д	Газар эзэмшигчдийн			Газрын		
	Эцэг эх, өөрийн нэр	Регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Хэмжээ /м2/	Байршил, хаяг
A	1	2	3	4	5	6
1	Илчлэг-Шивээ ОНӨҮГазар	2005123	4202000077	Зуух, албан контор	3000	3-р сургуулийн баруун талд
2	Илчлэг-Шивээ ОНӨҮГазар	2005123	4202000078	Усан сан	8438	Говьгоо ХХК-ийн буудлын хойд талд